

БАТЛАВ. ХАВДАР СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ЭРДЭНЭХҮҮ



БАГАЖ ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар. 2021/05

Улаанбаатар хот

Нэг талаас **Хавдар судлалын үндэсний төв** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "Жооги" **ХХК** (цаашид "нийлүүлэгч" гэх) нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 01 дүгээр сарын 4-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.


1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Хэт ягаан туяаны ариутгалын аппарат **нийлүүлэх, худалдан авах**-г (цаашид "бараа" гэх) **2.000.000 / Хоёр сая/ төгрөгийн бараа** (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг **2.000.000 /Хоёр сая/ төгрөгийг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.**
4. Нийлүүлэгч нь барааг **2021 оны 01 дүгээр сарын 05-ний өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн дотор** нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
 1. Гэрээний ерөнхий нөхцөл
 2. Гэрээний тусгай нөхцөл
 3. Техникийн тодорхойлолт Хавсралт 1
 4. Бараа нийлүүлэлтийн хуваарь Хавсралт 2
 5. Үнийн санал Хавсралт 3
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.




9. Төлбөрийн нөхцөл: Захиалагч нь чанарын шаардлага хангасан барааг хүлээн авсны дараа тооцоог дүгнэж төлбөрийг гүйцэтгэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Байгууламжийн менежмент,
Аюулгүй байдлын албаны дарга
Ц.Энхсаруул

.....


Санхүү, бүртгэлийн албаны
дарга Ц.Энхээ

.....


Эдийн засагч Д.Пхалгасүрэн

.....


Хаяг:

Хавдар судлалын үндэсний төв
БЗД-ийн 18-р хороо. Намянжүгийн
гудамж. Баянзүрх дүүрэг.

Утас: 450043,

Факс: 976-11-458189

Данс: Төрийн сан
100900020019

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Жооги" ХХК-ийн захирал Э.Батзэвэг

.....


Хаяг:

"Жооги" ХХК. 16-р хороо. БГДүүрэг.
5-97 тоот

Утас: 976-88545088

Факс:

Регистр: 5033551

Данс: Голомт банк 1410002409

